# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ /ТӨЛӨВЛӨГӨӨ/-НЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улаанбаатар хот

<table>
<tr><th>Д/Д</th><th>Зорилт</th><th>Хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th>Биелэлт</th></tr>
<tr><td>1</td><td rowspan="2">Авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах.</td><td>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг олон нийтэд сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</td><td>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөнд оруулах саналыг хэлтэсүүдээс авч тусган боловсруулан батлуулж хэлтсүүдэд хүргүүлэн, дүүргийн цахим хуудсанд PDF форматаар байршуулж хэрэгжилтийг хангах зорилгоор хэлтэс тус бүрт тарааж танилцуулсан.<br>/Баянзүрх дүүргийн албан ёсны вэб сайтад байршуулсан/</td></tr>
<tr><td>2</td><td>Авлигын эсрэг хууль тогтоомжийг албан хаагчид, иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах.</td><td>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг албан хаагчид, иргэдэд сурталчилах зорилгоор Засаг даргын Тамгын газар болон Тамгын газрын нийтийн номын сангийн мэдээллийн самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон зурагт хуудас, гарын авлагыг тогтмол байршуулан ажиллаа.<br><br><br>.<br>Мөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагуудын оруулж байгаа мэдээлэлтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах боломжийг хангаж төрийн сангийн төлбөр тооцооны танхимд иргэдийн хэрэглээнд зориулан компьютер байршуулж мөн Шилэн данс буланг нээн ажиллуулсан нь амжилттай хэрэгжиж иргэдэд хүртээмжтэй өгч байна.</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | |  |
| 3 | | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, гарсан шийдвэрийг цахим хуудсанд байршуулах: /нансаагаас тодруулах/ | Хэм хэмжээ тогтоосон захиргааны акт ЗДТГ-аас гардаггүй бөгөөд тус дүүргийн Засаг даргаас гаргасан А захирамжуудыг Нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сан болох http://ublegal.mn:8080/decision/MainPage сайтад мөн байгууллагын цахим хуудасны тогтоол шийдвэр буланд байршуулж хэвшсэн болно. |
| 4 | Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар соён гэрээрүүлэх сургалтыг санхүүгийн ажилтнуудын дунд зохион байгуулах. | Тухайн хуулийг сурталчилах, /мэдээллийн самбар, яриа таниулга, нээлттэй хэлэлцүүлэг, хэвэлмэл материал г.м/ | Тус дүүргийн Засаг даргын тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэстэй хамтран Тамгын газрын нийтийн номын санд 28 хороодын иргэдийг хамруулан давхардсан тоогоор 200 гаруй иргэдэд Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд яриа таниулга хийж хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан.   Мөн шилэн дансны хууль, журам, түүний хэрэгжилтийг иргэд олон нийтэд таниулах зорилгоор Гачууртийн Засаг даргын Тамгын газар, Гачууртын Нова өрхийн эмнэлэг, 63 дугаар цэцэрлэг, 85 дугаар сургууль, 21 дүгээр цэцэрлэгтэй хамтран зохион байгуулж ажилласан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | |   |
| 5 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөлтийн байдал<br>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байдал<br>Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ | Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албад болон харьяа хэлтэс албадаас хийж буй ажил, хяналт шалгалтын талаархи мэдээллийг тухай бүрт нь бэлтгэн хэлтэс албад тус бүр өөрсдийн албан ёсны цахим хуудсанд байршуулан ажилладаг. Тухайлбал Хүүхэд, гэр бүл хөгжлийн төвийн http://bayanzurkh.child.gov.mn/ цахим, тухай бүрт нь бэлтгэн олон нийтэд хүргэн ажиллаж гарсан зөрчлийг тухай бүр мэдээллийн самбарт байршуулан ажилласан. |
| 6 | “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд байршуулж мэдээлнэ. | Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/ өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулсан байдал<br>Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 01-ний дотор/-г цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байдал<br>Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсон өдрөөс ажлын 14 хоногт/<br>Төсвийн орлог бүрдүүлэлтийн нээлттэй байдал /Татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс дүүргийн bzd.ub.gov.mn цахим сайтны мэдээ гэсэн талбарын Санхүүгийн мэдээлэл дотор дараах мэдээллүүдийг байршуулсан. Үүнд:<br>1. 2016 оны Иргэдийн Төлөөлөгчдийн хуралаар дүүргийн төсвийн тодотголын хэлэлцэн баталсан бөгөөд бүх эдийн засгийн ангилалын дагуу шилэн дансанд байршуулсан.<br>2. 2015 оны дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2016 оны 1 дүгээр сарын 13-нд<br>3. Дүүргийн орон нутгийн байгууллагуудын 2017 оны төсвийн төслийг Нийслэлийн шилэн дансны цахим хуудсанд 2 дугаар хавсралтын дагуу 10 дугаар сарын 22-нд<br>4. Дүүргийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, дүүргийн нэгдсэн тайланд хийсэн аудитын гэрчилгээг PDF форматаар байршуулсан<br>5. Төсвийн орлого бүрдүүлэлтийн нээлттэй байдлыг хангах үүднээс татварын орлогын талаарх мэдээг Нийслэлийн шилэн дансны цахим хуудсанд 4 дүгээр хавсралтын дагуу тус тус байршуулан ажилласан. |
| 7 | Гадаад зээл тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх. | Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл нээлттэй байх | Тус дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь Япон улсын хөрөнгөөр санхүүжиж буй хөтөлбөрийг өдөр үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болох Үндэсний шуудан сонин болон Сангийн яамны www.e procurement.mof.gov. mn сайтад тус тус байршуулан ажилласан.<br>**/НОТЛОХ БАРИМТ-4/** |
| 8 | Цахим хуудасны мэдээллийг сайжруулах, мэдээллийг төрөлжүүлэх | Заавал байх мэдээллийн жагсаалт гаргах | Тус дүүргийн албан ёсны веб сайт www.bzd.ub.gov.mn-д шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь байршуулдаг. |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах. | Байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал. | Байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт нь тус дүүргийн www.bzd.ub.gov.mn цахим сайтын мэдээ гэсэн талбарт мөн байгууллагын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан. Мөн Нийгмийн хөгжлийн хэлтсээс олгож буй хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт, уг үнэмлэхийн асуудлыг шийдвэрлэх журмыг хэлтсийн мэдээллийн самбар болон тус дүүргийн 28-н хороодын мэдээлийн самбарт байршуулж иргэд олон нийтийг саадгүй танилцах боломжийг хангаж   ажилладаг.<br>Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 1723 аж ахуйн нэгж, иргэдэд байгууллагаас олгож буй зөвшөөрөл, шаардлагатай бичиг баримтын жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдлыг хангах зорилгоор сургалт зохион байгуулж мөн гарын авлага, брошур, хэвлэлмэл материал, мөрдөгдөж буй журмыг тарааж ажиллав. Гэрээ байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг хэлтсийн мэдээллийн самбар болон “Худалдаа, үйлчилгээ Баянзүрх дүүрэг” Фэйсбүүк хаягт тогтмол байршуулан ажиллаж байна. **/НОТЛОХ БАРИМТ-1/**   |

| | | | |
|---|---|---|---|
| | | |   |
| 10 | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн аж ахуйн нэгжийн нэр, хаяг, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа үйл ажиллагааны байршлыг багтаасан мэдээллийн санг бүрдүүлж, цахим хуудсанд байршуулж тухай бүр шинэчилж байх. | Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хууль тогтоомжид заасны бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/ | "Тамхины хяналтын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиас 500 метрийн зайд үйл ажиллагаа явуулдаг, аж ахуй нэгж, иргэнд дүүргийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл шинээр олгох болон сунгалт хийж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг "Баянзүрх дүүргийн нэгдсэн бүртгэлийн сан"-д /bzd.4.sodonsolution.org/ тухай бүр оруулан шинэчилж, мэдээллийн бааз суурийг бий болгож ажиллаж байна. |
| 11 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журам, тендерийн урилга, тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлтүүдийг нээлттэй, ил тод байршуулах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах<br>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байдал<br>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх<br>Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй оролцогчдын талаарх нээлттэй байдал<br>Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний тайланг нээлттэй байлгах<br>Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээллэх<br>Худалдан авах ажиллагаанд хийсэн | Тус дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь заалтын дагуу 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болох Үндэсний шуудан сонин болон Сангийн яамны www.e-procurement.mof.gov. mn сайтад байршуулан нийтэд зарлан мэдээлэж ажилласан.<br>Ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор тендерийн урилгыг Засгийн газрын мэдээ сонин, Үндэсний шуудан сонин болон Сангийн яамны www.e-procurement.mof.gov.mn, Албаны bzd-procurement.ub.gov.mn сайтуудад нийт 26 ажлын урилгыг тухай бүр байршуулж ажилласан байна.<br>Зохион байгуулсан тендер шалгаруулалтын шалгарсан болон шалгараагүй шалтгаан нөхцлийг тендерт оролцсон аж ахуйн нэгж нарт албан бичиг болон |

| | | | |
|---|---|---|---|
| | | аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаар нээлттэй байлгах<br>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал | Сангийн яамны www.e-procurement.mof.gov.mn, Албаны bzd-procurement.ub.gov.mn сайтуудад тогтмол байршуулсан. Мөн тендер шалгаруулалтын явцын мэдээг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт долоо хоног бүрийн 5 дахь өдөр бүр, Тендер шалгаруулалтын тайланг улирал бүр Сангийн яам, НЗДТГ-ын дэргэдэх Хяналт үнэлгээ, шинжилгээний хэлтэст, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтын дагуу Иргэдийн төлөөлөгчдын хурлын ажлын албанд тендерийн үнэлгээний хорооны бүрэлдхүүнд оролцох хүсэлт ирүүлсэн АЗ гэрчилгээтэй иргэдийн нэрсийн жагсаалт ирүүлсэний дагуу үнэлгээний хороонд оролцуулан ажиллаж байна. “Залуу тэнгис” ТББ-ийн төлөөллийг Үнэлгээний хороонд оролцуулан ажилласан.<br>**/НОТЛОХ БАРИМТ-2/** |
| 12 | Тендер шадгаруулалтын явцад илэрсэн зөрчил, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийг ил тод мэдээлнэ. | | Тендер шалгаруулалтын шалгарсан болон шалгараагүй шалтгаан нөхцлийг албаны www.bzd-procurement.ub.gov.mn, Сангийн яамны www.e-procurement.mof.gov.mn, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын http://ub-procurement.mn/ сайтад тухай бүр тогтмол байршуулж байна. Мөн зохион байгуулсан тендер шалгаруулалтын шалгарсан болон шалгараагүй шалтгаан нөхцлийг тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдэд албан бичгээр тогтмол хүргүүлэн ажилладаг. |
| 13 | Тендер шалгаруулалтын тайлан мэдээ, аудитын дүгнэлт, хяналт шалгалтын дүнгийн талаар нээлттэй ил тод мэдээлнэ. | | Тендер шалгаруулалтын явцын мэдээг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт долоо хоног бүрийн 5 дахь өдөр бүр, Тендер шалгаруулалтын тайланг улирал бүр Сангийн яам, НЗДТГ-ын дэргэдэх Хяналт үнэлгээ, шинжилгээний хэлтэст, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус тус хүргүүлэн ажилладаг. |
| 14 | Худалдан авах ажиллагаа “Видео тендер” болон бусад хэлбэрээр зохион | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хагас жилд нэг удаа | Одоогоор “Видео тендер” хэлбэрээр зохион байгуулагдаагүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулж, тендерийн ил тод байдлыг сурталчилах | “Видео тендер” хэлбэрээр зохион байгуулах | |
| 15 | Нийтийн албанд хувийн ашиг сонирхлын нөлөөг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх | Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах. | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэн дүгнэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд төсвийн шууд захирагч, нэгжийн менежер болон хамт олны дунд нээлттэй үнэлж, дүгнэх үйл ажиллагааг явуулж хэвшсэнээр төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг хариуцлага, мэдлэг чадвар дээшилдэг.<br><br>Мөн төрийн албаны зөвлөлөөс гаргасан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| 16 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийт түүнтэй танилцах боломжоор хангах | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах<br>Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар тухай бүр шинэчилэн байршуулах | “Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд сул орон тоо нөхөх хүсэлт хүргүүлэн гаргасан дүгнэлтийн дагуу нийт 4 ажлын байрыг нөөцөөс нөхөж ажиллалаа.<br><br>**/НОТЛОХ БАРИМТ-3/** |
| 17 | Албан хаагчдын ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах, журмыг мөрдүүлэх | Сайн засаглалын стандартыг нийтийн албанд нэвтрүүлэх, иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн тогтвортой, төрийн албан хаагчийг бүх шатанд бэлтгэх | Сайн засаглалын стандартыг нийтийн албанд нэвтрүүлэх, иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн тогтвортой, төрийн албан хаагчийг бүх шатанд бэлтгэх ажлын хүрээнд Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоолыг үйл ажиллагаандаа мөрлөг болгон ажилладаг. Мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажлын цагийн хөнгөлөлт үзүүлэн суралцах нөхцөл бололцоог хангах ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.<br>**/НОТЛОХ БАРИМТ-6/** |
| 18 | Албан хаагчийн ажил үүргийн хувиарыг тодорхой болгож ил байршуулан, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх боломжийг бүрдүүлнэ. | Төрийн албан хаагчийн ажил үүргийн хувиарыг тодорхой болгож, нийтэд мэдээлж, дүүргийн цахим хуудсанд байршуулах. | Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлэн ажиллаж байна.<br>Албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэл, утасны дугаарын хамт цахимд байршуулсан болно. |
| 19 | Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох | Эрх бүхий албан тушаалтныг томилсон байх<br>Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтонд тусгасан байх<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй сургалтанд хамрагдсан байх<br>Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангах баталгаа гаргах | Тамгын газрын даргын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/144 тоот тушаалаар эрх бүхий албан тушаалтныг томилсон.<br>Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тусгасан болно.<br>АТГ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй сургалтад тогтмол хамрагддаг.<br>Хувь хүний нууцтай холбогдсон мэдээ, материалыг хадгалах хамгаалах |

| | | | |
|---|---|---|---|
| | мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцлийг хангах | Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнг дүгнэж үзэх<br>Эрх бүхий албан тушаалтны цалингийн зохих нэмэгдлийг олгож, тогтвортой ажиллуулсан байх | баталгааг байгууллагын даргад гаргасан ба хадгалалт хамгаалалтын зориулалтаар тусгай цоожтой сейф хэрэглэдэг болно.<br>Эрх бүхий албан туушаалтныг тогтвортой ажиллуулах зорилгоор цалингийн зохих хувийг Тамгын газрын даргын 2013 оны Б/144 тоот тушаалаар олгож байна. |
| 20 | Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж цахим хуудас, мэдээлийн самбарт байршуулах<br>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын нээлттэй байдлыг хангах<br>Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамжийн талаарх мэдээллийн ил тод байдал | Цахим хуудсанд байршуулсан байх<br>Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх | Тус дүүргийн Засаг даргаас гаргасан А захирамжуудыг байгууллагын цахим хуудасны тогтоол шийдвэр буланд байршуулж хэвшсэн болно. |
| 21 | Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй уулзах уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын хэрэгжилтийг хангуулах | Дүүргийн Засаг даргатай иргэд хүлээн авах хуваарийн дагуу 2016 оны 3 дугаар улиралд 352 иргэн уулзах хүсэлт тавьсны дагуу 8 удаагийн уулзалтыг зохион байгуулж, 146 иргэнтэй уулзаж хүсэлтийг холбогдох хэлтэс албадад шилжүүлэн шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Засаг даргын Иргэд хүлээн авах уулзалтыг ЗДТГ-ын Соёмбо танхимд зохион байгуулахын зэрэгцээ шаардагдах техник хэрэгслээр хангаан Тамгын газрын Хэвлэл мэдээллийн алба болон даргын туслах нар тухай бүр тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.<br>Засаг даргын Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогчАхмадын орон сууцны хөтөлбөр, Өмч газрын харилцааны алба Худалдаа, үйлчилгээ эрхлэх зохицуулах зөвлөлийн талаар 2 удаагийн уулзалтаар 12 иргэнтэй, Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч-Хөдөлмөр, халамж, боловсролын байгууллага, тухайн байгууллагын ажиллагсад, 25 иргэнтэй өөрсдийн хариуцсан асуудлын хүрээнд уулзаж уулзалтын тэмдэглэл хөтөлсөн.<br>Иргэдтэй хийх уулзалтын хуваарь, хэлэлцэх асуудал, уулзалтын тайлангийн талаарх мэдээллийг удирдлагад танилцуулан тамгын газрын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хэвлэл мэдээллийн албанд хүргүүлэн мэдээллийн самбарт мэдээлэн ажиллаж байна. |
| 22 | Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах олон нийттэй харилцах албаны үйлчилгээг өргөжүүлж, иргэдийн санал, хүсэлтийн хайрцаг, амаар болон бичгээр, нээлттэй утас, face book, twitter зэрэг мэдээллийн сурвалжуудаар хүлээн авч шийдвэрлэнэ. | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэд хүлээн авах хувиарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх<br>Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлыг мэдээллийн самбарт тогтмол хугацаанд мэдээлсэн байх<br>Ашиг сонирхлын зөрчлийн тараарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж, хариуцлага тооцсон байдал | Үйлчилгээ захидал хариулцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх /-ийн нэр өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утасны дугаар ,цахим хаягийг www.ub12008 www.smart city.mn болон www. bzd.ub.gov.mn дүүргийн цахим хуудаст байршуулж ажилласан.<br>Тус дүүрэг нь www.smartcity.mn цахим өргөдөл гомдлын системээр дамжуулан Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2016.01.04-ны өдрөөс 2016.09.23 хүртэлх хугацаанд нийт 6 эх үүсвэрээр буюу Call center-1200 тусгай дугаарын утсаар **286,** ub1200.mn цахим хуудсаар **16**, Засгийн газрын 11-11 төвөөр **461**, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр **23,** дүүргийн тамгын газар болон Засаг даргад хандсан өргөдөл **433,** Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн **4**, Мессеж **1** буюу нийт **1224** өргөдөл, хүсэлт, санал, гомдол, талархал, шүүмжлэл ирсэн. Иргэдээс ирүүлсэн эдгээр 1224 өргөдөл, хүсэлтийн **1183** буюу **96,6 %**-ийг нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх шатандаа 38 өргөдөл, бүртгэгдсэн байна.<br>Баянзүрх дүүргийн Засаг даргын газарт болон цахим шуудангаар ирсэн **114** өргөдөл, гомдлын хариуг иргэдэд гэрийнх нь хаягаар шуудангаар хүргүүлж ажиллалаа.<br>Мөн 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн дээр хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэсэн өргөдлийн мэдээний тайланг бэлтгэн хэлтэс бүрээр гарган удирдлагуудад танилцуулан, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд тогтмол хяналт тавьж, дүн шинжилгээ хийх үүднээс улирал тутам байгууллагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллах талаар төлөвлөгөөнд тусганхэлтсийн мэдээллийн самбарт 7 хоног бүр байршуулан ажиллаж байна.<br>Тайлангийн хугацаанд ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэдээс гомдол мэдээлэл ирээгүй болно |
| 23 | Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, ажилтны үйл ажиллагааг хянах, урьдчилан сэргийлэх. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүнд суртал чирэгдэлийг багасгах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр ажлын байрны тодорхойлолтод Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагыг тавьж мөрдүүлэн ажиллахын зэрэгцээ сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан болно.<br>Үүнд: Тамгын газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/26, Б/230 дугаар тушаалаар зохион байгуулагч, нийгмийн ажилтныг сэлгүүлэн ажиллуулсан болно. |
| 24 | Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс | Судалгаа гаргаж зөрчил гарсан тохиолдолд гэрээ цуцлуулах арга хэмжээг | Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрладаг эсэх талаар судалгааг хийсэн бөгөөд төрийн байгууллагын байранд байрласан аж ахуйн нэгж байгууллага байхгүй |

| | | | |
|---|---|---|---|
| | бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглох. | авахуулах. | байна.<br>**/НОТЛОХ БАРИМТ-5/** |
| 25 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх. | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-с зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-с арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт<br>АТГ-ын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбоглох этгээд болон нийтэд өөрийн зардалаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлт. | Авлигатай тэмцэх газраас 2016 оны байдлаар зөрчил арилгуулах талаар албан бичиг ирээгүй болно.<br><br>Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдэл байхгүй байна.<br><br>АТГ-ын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардалаар хүргэх арга хэмжээний журам”-тай холбоотой зөрчил гараагүй байна. |
| **Авлигатай тэмцэх санал, санаачлага.** | | | |
| 26 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт. | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал<br>Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал<br>Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал. | Тайлангийн хугацаанд тус дүүргийн удирдлагын зөвлөл нь төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлага, тулгамдаж буй асуудлаар нийт 19 удаа хуралдаж, аливаа асуудлыг хамтын шийдвэрээр шийдвэрлэж хэвшсэн бөгөөд удирдлагын зөвлөлөөс гаргасан шийдвэр, үүрэг даалгаврыг дүүргийн албан ёсны вэб сайтад байршуулсан. |
| 27 | | Албан тушаалтан, албан хаагчдын шудрага байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шудрага ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м /-ний үр дүн. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийг албан тушаалтан, албан хаагчдад тараан судлуулсанаар хуулийг үйл ажиллагаандаа чанд биелүүлэн ажилладаг болж улмаар тайлангийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил гараагүй болно. |
| 28 | Албан хаагчдийн шудрага байдал ба түүнийг нэмэгдүүлэх. | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ<br>Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ | Байгууллагын дотоод хяналт, шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил гараагүй байна.<br>Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил гараагүй.<br>Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг, зөрчил гараагүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил. | |

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|
| | | | **1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт** | | |
| 1. | Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг олон хэрэгжүүлэх, нийтэд сурталчлах, ажлыг зохион байгуулах. | Тогтмол | Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт<br><br>Авлигатай тэмцэх газраас өгөгдсөн үүрэг даалгавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байх | Захиргаа, хуулийн хэлтэс, ЭБАТ Г.Батцэцэг | Байгууллагын ажилтнууд болон олон нийт мэдээлэлтэй болж шударга ажиллах, амьдрах итгэл үнэмшил бий болно. |
| 2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг албан хаагчид, иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br><br>- Авлигын эсрэг хууль<br>- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын | Тухай бүр | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах,<br>- мэдээллийн самбар<br>- цахим хуудас,<br>-хэвлэлмэл материалаар<br>- нэжэлттэй хэлэлцүүлэг<br>- яриа таниулга гэх мэт | Захиргаа, хуулийн хэлтэс, ЭБАТ Г.Батцэцэг | Албан хаагчид, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшлэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль | | | | |
| 3 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох<br><br>Эрх зүйн үндэслэл нь:<br>- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2.<br>- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | Тухай бүр | Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байдал<br>Дээрх бодлогын баримт бичиг болон шийдвэрийн төслийг иргэний танхимаар хэлэлцүүлэх, санал солилцох боломжийг бүрдүүлсэн байх. | Захиргаа, хуулийн хэлтэс,<br><br>Хэвлэл мэдээллийн алба. | Олон нийтийн санаа бодлыг тусгаж чадах |
| 4 | Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,<br>Авлигын эсрэг хуулийн хүрээнд сургалт зохион байгуулах. | 1,2 дугаар улирал | Тухайн хуулийг сурталчлах, /мэдээллийн самбар, яриа таниулга, нээлттэй хэлэлцүүлэг хэвлэлмэл материал г.м/ | Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтрах | Албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшлэх |
| 5 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 | 1 дүгээр улирал<br><br>Хийгдсэн шалгалтын дараа | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөлтийн байдал<br>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байдал<br><br>Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ | Дотоод аудитын алба | Хариуцлагын тогтолцоо бий болно. |
| 5 | “Шилэн дансны тухай хуулийн | | Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/ өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд байршуулж мэдээлнэ. | 1 дүгээр улирал | төсөл / 8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулсан байдал<br>Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 01-ний дотор/-г цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байдал<br>Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсон өдрөөс ажлын 14 хоногт/<br>Төсвийн орлог бүрдүүлэлтийн нээлттэй байдал /Татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | ЗДТГ<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс | |
| 7 | Гадаад зээл тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх. | Тухай бүр | Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл нээлттэй байх | Санхүү төрийн сангийн хэлтэс<br>Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 8 | Цахим хуудасны мэдээллийг сайжруулах, мэдээллийг төрөлжүүлэх | Тухай бүр | Заавал байх мэдээллийн жагсаалт гаргах | Засаг даргын Тамгын газар | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 9. | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах. | Тухай бүр | Байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал. | Худалдаа үйлчилгээний хэлтэс,<br>Дэд бүтэц тохижилтийн хэлтэс,<br>Нийгмийн хөгжлийн хэлтэс | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 10<br>11. | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн аж ахуйн нэгжийн нэр, хаяг, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа үйл ажиллагааны байршлыг | Тухай бүр | Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан | ЗДТГ | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | багтаасан мэдээллийн санг бүрдүүлж, цахим хуудсанд байршуулж тухай бүр шинэчилж байх. | | бүртгэлүүд/ | | |
| 12. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журам, тендерийн урилга, тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлтүүдийг нээлттэй, ил тод байршуулах | Тухай бүр | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах<br>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байдал<br>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх<br>Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй оролцогчдын талаарх нээлттэй байдал<br>Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний тайланг нээлттэй байлгах<br>Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээллэх<br>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаар нээлттэй байлгах<br>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал | Худалдан авах ажиллагааны алба | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 13. | Тендер шадгаруулалтын явцад илэрсэн зөрчил, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийг ил тод мэдээлнэ. | Тухай бүр | | | |
| 14. | Тендер шалгаруулалтын тайлан мэдээ, аудитын дүгнэлт, хяналт шалгалтын дүнгийн талаар нээлттэй ил тод мэдээлнэ. | | | | |
| 15 | Худалдан авах үйл ажиллагааг “Видео тендер” болон бусад | Жилдээ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил | Худалдан авах ажиллагааны | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэлбэрээр зохион байгуулж, тендерийн ил тод байдлыг сурталчилах | | үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хаг ас жилд нэг удаа “Видео тендер” хэлбэрээр зохион байгуулах | алба | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 16 | Нийтийн албанд хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх | Тухай бүр | Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах | Хүний нөөц Г.Батцэцэг | Хуулийн хэрэгжилт хангагдана. |
| 17. | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийт түүнтэй танилцах боломжоор хангах | Тухай бүр | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах<br>Сонгон шалгаруулалтыг шударгаар өрсөлдүүлэн шалгаруулах | Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Батцэцэг | Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд хангагдана |
| 18 | Нийтийн албанд хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх | Тогтмол | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүгнэлт гаргуулахгүй албан тушаалд томилсон тохиолдолд томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага тооцох, нийтэд мэдээлэх | Эрх бүхий албан тушаалтан Г.Батцэцэг | Хуулийн хэрэгжилт хангагдана. |
| 19 | Албан хаагчдын ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах, журмыг мөрдүүлэх | Хагас, бүтэн жилд | Сайн засаглалын стандартыг нийтийн албанд нэвтрүүлэх, иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн тогтвортой, төрийн албан хаагчийг бүх шатанд бэлтгэх | Засаг даргын Тамгын газар | Ажилтны ажлын үүрэг хариуцлага нэмэгдэнэ. |
| 20. | Албан хаагчийн ажил үүргийн хувиарыг тодорхой болгож ил байршуулан, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх боломжийг бүрдүүлнэ. | 1 дүгээр улирал | Төрийн албан хаагчийн ажил үүргийн хувиарыг тодорхой болгож, нийтэд мэдээлж, дүүргийн цахим хуудсанд байршуулах. | Захиргаа, хуулийн хэлтэс | Ажилтны ажлын үүрэг хариуцлага нэмэгдэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцлийг хангах | 1 дүгээр улирал | Эрх бүхий албан тушаалтныг томилсон байх<br>Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтонд тусгасан байх<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй сургалтанд хамрагдсан байх<br>Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангах баталгаа гаргах<br>Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнг дүгнэж үзэх<br>Эрх бүхий албан тушаалтны цалингийн зохих нэмэгдлийг олгож, тогтвортой ажиллуулсан байх | ЗДТГ | Авлигаас урьдчилан сэргийлэх байдал хангагдана. |
| 22 | Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж цахим хуудас, мэдээлийн самбарт байршуулах<br>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын нээлттэй байдлыг хангах<br>Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамжийн талаарх мэдээллийн ил тод байдал | Тухай бүр | Цахим хуудсанд байршуулсан байх<br><br>Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх | ЗДТГ | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хангагдана |
| 23 | Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэн эрсдлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 1 дүгээр улирал | “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй уулзах уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын хэрэгжилтийг хангуулах | Захиргаа, хуулийн хэлтэс | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хангагдана |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах олон нийттэй харилцах албаны үйлчилгээг өргөжүүлж, иргэдийн санал, хүсэлтийн хайрцаг, амаар болон бичгээр, нээлттэй утас, facebook, twitter зэрэг мэдээллийн сурвалжуудаар хүлээн авч шийдвэрлэнэ. | Тухай бүр | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэд хүлээн авах хувиарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх<br>Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлыг мэдээллийн самбарт тогтмол хугацаанд мэдээлсэн байх<br>Ашиг сонирхлын зөрчлийн тараарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж, хариуцлага тооцсон байдал | ЗДТГ | Иргэдэд ил тод чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх байдалд ахиц гарна. Хариуцлагын тогтолцоо бий болно |
| 25. | Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, ажилтны үйл ажиллагааг хянах, урьдчилан сэргийлэх. | | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүнд суртал чирэгдэлийг багасгах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах. | ЗДТГ | Авлигад үл өртөх байдал хангагдана |
| 26 | Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглох. | 1 дүгээр улирал | Судалгаа гаргаж зөрчил гарсан тохиолдолд гэрээ цуцлуулах арга хэмжээг авахуулах. | ЗДТГ | Хуулийн хэрэгжилт хангагдана. |
| | | | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион | Засаг даргын | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 27. | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх. | Тухай бүр | байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-с зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт<br>АТГ-с арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт<br>АТГ-ын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбоглох этгээд болон нийтэд өөрийн зардалаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлт. | Тамгын газар, холбогдох харьяа хэлтэс, албад | Хууль, тушаал шийдвэрийн биелэлтийн байдал хангагдах |
| **Авлигатай тэмцэх санал, санаачлага** | | | | | |
| 28. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт. | Тухай бүр | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал<br>Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал<br>Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал | Дүүргийн Засаг даргын Тамгын газар | Ажилтан албан хаагчид, иргэд олон нийтийн шудрага ажиллах, амьдрах итгэл үнэмшил бий болно. |
| | Албан хаагчдийн шудрага байдал ба түүнийг нэмэгдүүлэх. | | Албан тушаалтан, албан хаагчдын шудрага байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шудрага ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м /-ний үр | Захиргаа, хуулийн хэлтэс | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 29. | | Тухай бүр | дүн. | | |
| | | | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ<br>Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ<br>Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил. | ЗДТГ | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хангагдана |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН: ЭБАТ Г.БАТЦЭЦЭГ